

## Гудамж, зам, талбайн хягжуулалтын техникийн тодорхойлолт

Мөрдөх норм стандарт, дүрэм

1. 2013 оны Засгийн газрын 280 дугаар тогтоол” Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журам”
2. Монгол улсын ” Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах тэмдэглэгээнд тавих ерөнхий шаардлага “ MNS 5283:2014 стандарт

Техникийн шаардлага :

1. Хаягийн самбарын материал нь MNS 5283:2014 стандартад заасны дагуу байгалийн үзэгдэлд тэсвэрлэхүйц, зэвэрдэггүй металл байх эсвэл хамгаалалтын гадаргуутай байна.
2. Гудамж хашааны хаягийн төмрийн зузаан нь **2-3мм**, бусад тэмдэгийн зузаан нь **3- 5мм** байна.
3. Хашааны хаалганы тэмдгийг явган хаалганы баруун талд стандартад дурьдсан хэмжээнд байна.
4. Хаягийн тэмдгийн дэвсгэр нь RGB/0.131.73/ код бүхий ногоон өнгөтэй, байгалийн аливаа үзэгдэлд хуурч гандахгүй, шөнийн цагт саадгүй харагдах, тээврийн хэрэгсэлийн болон бусад төрлийн гэрлийн тусгалаар гэрэлтдэг материалаар хийсэн байх.
5. Хаягийн тэмдгийн тулгуур суурийг барилгын зургийн инженерийн зураг төслөөр хийж, хянаж шалгасан , батлагдсан орц, нормын дагуу хийж, байгалийн аливаа үзэгдэлд тэсвэртэй, мал амьтан налж, шөргөөхөд унахааргүй бат бөх суурилуулсан байх.
6. Хаягийн самбарыг ангилал төрлөөс хамааран стандартад заасан хэмжээгээр хийж гүйцэтгэсэн байх.
7. Хаягийн тэмдэг нь гүйцэтгэгч 5-н жилийн баталгаа гаргаж өгөхүйц чанартай байна.
8. Гүйцэтгэсэн ажлын талаар дэлгэрэнгүй тайландаа тодорхой тусгасан байна.
9. Гэр хорооллын гудамжны хаягийн тэмдгийн баруун үзүүрт тухайн гудамжинд хамаарах хашаануудын дугаарыг бичсэн байна.

### Бараа материалын захиалга:

1. Өргөн чөлөө , гудамжны хаягийн тэмдэг /1000\*250/ хэмжээтэй - ??? ширхэг хаяг
2. Гэр хорооллын гудамжны хаягийн тэмдэг /400\*120/ хэмжээтэй - 500 ширхэг хаяг
3. Байшин барилгын дугаар /500\*500/ хэмжээтэй - 7 ширхэг хаяг
4. Орон сууцны орцын дугаар /400\*120/хэмжээтэй- 21 ширхэг хаяг
5. Хашааны дугаар /150\*100/ хэмжээтэй - 4500 ширхэг хаяг

